

БОГД СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН  
ХОРООНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2020 оны 06 сарын 23

Хориулт

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО НЬ: Ард иргэдийнхээ ая тухтай амгалан тайван орчинд амьдрах, ажилтай орлоготой байх нөхцөлийг хангаж, чадвартай, ил тод, идэвх санаачилгатай, иргэдийн оролцоог хангасан, авлига ашиг сонирхлын зөрчилгүй, иргэдийнхээ итгэл, дэмжлэгийг хүлээсэн, нутгийн удирдлагын хариуцлагатай тогтолцоог төлөвшүүлнэ.

**НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

**1.1 Орлоготой иргэн**

- 1.1.1 “Айл хотлоороо үйлдвэрлэгч” аян өрнүүлж жижиг үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг лизинг, бартерын аргаар нийлүүлнэ.
- 1.1.2 Үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор “Өрхийн үйлдвэрлэгчдийн өдөрлөг”-ийг жил бүр тогтмол зохион байгуулж аймаг, бүсийн хэмжээнд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.
- 1.1.3 Иргэдийн эдийн засгийн боловсролыг дээшлүүлж, хуримтлалтай болгох, амьдралаа зөв авч явах арга ухаанд сургах ажлыг системтэйгээр зохион байгуулна.
- 1.1.4 Иргэддээ ажил мэргэжлийн чиг баримжаа олгох төрөлжсөн сургалтуудыг зохион байгуулж, туршлага ур чадварт нь түшиглэн хувиараа хөдөлмөр эрхлэх боломжийг хангаж шаардлагатай тоног төхөөрөмжийн хөнгөлөлттэй зээл олгоно.
- 1.1.5 Иргэдийн дунд заавал хэвшүүлэх дадал, хэвшил бий болгож аливаа бодлого шийдвэрт иргэдийн санаа бодлыг тусгадаг байх зарчмыг хэрэгжүүлнэ.
- 1.1.6 Сум, байгууллагын төсвийг төлөвлөх, батлах үйл ажиллагаанд иргэдийг оролцуулан шийдвэрлэдэг байх тогтолцоог бүрдүүлж төсвийг иргэдэд тогтмол тайлагнана.
- 1.1.7 Сумандаа жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж хөнгөлөлттэй зээлд хамруулна.
- 1.1.8 Сумын хэмжээнд байнгын шинэ ажлын байр бий болгосон үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжиж, хөнгөлөлттэй зээл, төслөөр дэмжлэг үзүүлж ажиллана.
- 1.1.9 Орлого багатай өрхийн ажил эрхлээгүй насанд хүрсэн гишүүдийг мэргэжил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтанд хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

**1.2 Эрүүл иргэн**

- 1.2.1 Сумын халуун усны үйлчилгээг байнгын ажиллагаатай болгоно.

000000001  
*Д.Өлзийбаяр*





- 1.2.2 Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа, эмч ажиллагсдын ёс зүйд хяналт тавих, мэдээлэх, шаардлага тавих эрх бүхий "Иргэний зөвлөл"-ийг эрүүл мэндийн байгууллагын дэргэд байгуулна.
- 1.2.3 Хүн амын өвчлөл, нас баралтад нөлөөлж буй буруу дадал хэвшил, ундны усны хатуулаг, хөрс, агаарын бохирдлыг буруулах арга хэмжээг авна.
- 1.2.4 Халдварт өвчний гарч буй нөхцөлийг тодорхой болгож, гаралтыг улс аймгийн дунджаас доогуур түвшинд хүргэж, устгах боломжийг эрэлхийлэх ажлыг тухай бүрт нь авч хэрэгжүүлнэ.
- 1.2.5 Багийн эмч ажилтнуудын нийгмийн баталгааг хангах, стандартад нийцсэн ажлын байр, техник хэрэгслээр хангаж, иргэдийг жилд 1-2 удаа эмнэлгийн нарийн мэргэжлийн үзлэг оношилгоонд хамруулна.
- 1.2.6 Багийн эмч нарыг унаажуулна.
- 1.2.7 Түйн голын голдиролыг өөрчилж булгийн эхийг хамгаалалтад авч, сумын төвийн ундны усны худгуудыг шинжилгээнд хамруулж эрүүл ахуйн хяналтыг тогтмол тавина.
- 1.2.8 "Идэвхтэй хөдөлгөөн урт нас" аян өрнүүлж нийтийн биеийн тамирыг дэмжинэ.
- 1.2.9 Рашаан сувилал, нуурын давс, шавар бариа, элс, ингэний ундаа, гүүний саам, эмийн ургамал ашиглан уламжлалт эмчилгээ, сувилал байгуулах санал, санаачилгыг дэмжинэ.
- 1.2.10 Иргэдийг эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилго бүхий "Амар тайван амьдрал" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.2.11 Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл амьдралын зөв дадлыг төлөвшүүлэх чиглэлээр сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулна.
- 1.2.12 Ахмад өндөр настнуудыг чөлөөт цагаа өнгөрүүлэх, үйлдвэрлэл үйл ажиллагаа явуулах байртай болгож "Ахмадаа ачилъя" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.2.13 Ахмад настнуудыг рашаан сувилалд зохион байгуулалттайгаар амруулах нөхцөл бололцоогоор хангана.
- 1.2.14 Эрүүл мэндийн оношилгооны чадавхыг дээшлүүлж, эмч мэргэжилтнүүдийг нарийн мэргэжлээр бэлтгэн иргэн бүр бүрэн эрүүл мэндийн үзлэг оношилгоо мэдээллийг дээд шатлалын эмнэлгүүдтэй цахимаар солилцох тогтолцоог бүрдүүлнэ.
- 1.2.15 Эрүүл мэндийн байгууллагын ёс зүйн салбар хороодын үйл ажиллагааг тогтмолжуулж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулан, нийгэмд эерэг хандлагыг бий болгоход чиглэсэн "Эрүүл мэндийн салбарын эелдэг ажилтан" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана.
- 1.2.16 Сум дундын эмнэлгийн барилгад их засвар хийнэ.
- 1.2.17 "Эрүүл хүүхэд", "Эрүүл шүд" хөтөлбөрийг үргэлжлүүлж бага насны хүүхдийг эрүүл мэндийн эрсдэлээс сэргийлж, "Эрүүл ирээдүй" хөтөлбөр хэрэгжүүлнэ.

### 1.3 Чанартай боловсрол

- 1.3.1 Сурагчдын дотуур байрны барилгыг барьж дуусган хичээлийн байрыг өргөтгөх засварлах, шинээр барих ажлыг холбогдох газарт уламжилж шийдвэрлэнэ.





- 1.3.2 “Монгол бичиг” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, төрийн албан хаагчид, иргэдийг шат дараатайгаар сургалтад хамруулж, сурах нөхцөл бололцоогоор хангана.
- 1.3.3 Сурагчдад зориулсан орон нутгийн аяллын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.
- 1.3.4 Соёл амралтын задгай театр байгуулж иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх нөхцөлийг бий болгоно.
- 1.3.5 ЕБС-ийг түшиглэн гүйлтийн зам, хөл бөмбөгийн талбай бүхий биеийн тамирын талбайг бий болгоно.
- 1.3.6 Өвлийн спортыг хөгжүүлэх боломжийг судалж, өвлийн баярыг тогтмол хийж хэвшүүлнэ.
- 1.3.7 Сумд дутагдалтай байгаа хөгжим бүжгийн багш, математикийн багш зэрэг нэн шаардлагатай мэргэжилтнүүдийг бодлогоор дэмжин тогтвор суурьшилтай ажиллуулна.
- 1.3.8 Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын орчны стандартыг хангуулж ажиллана.
- 1.3.9 Иргэдийн эрүүл мэнд, бие бялдрыг хөгжүүлэх, чийрэгжүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.
- 1.3.10 Сургуулийн биеийн тамирын талбай, цэцэрлэгт хүрээлэнд нэмэлт тохижилт хийж ашиглалт хамгаалалтыг сайжруулж аюулгүй орчин бүрдүүлж ажиллана.
- 1.3.11 240 хүүхдийн бага сургуулийн барилга барьж ашиглалтад оруулна.

#### 1.4 Тогтвортой-амар амгалан гэр бүл

- 1.4.1 Гэр бүлийг дэмжсэн бодлого боловсруулан, гэр бүл төлөвлөлт харилцаа хандлагыг дээшлүүлсэн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

#### 1.5 Хүүхэд хамгаалал, хөгжлийн чиглэлээр

- 1.5.1 Хүүхдийн хөгжил, хамгаалал, төлөвшилтийг сайжруулах орчинг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 1.5.2 Хүүхэд, багачуудын бие даах чадварыг нэмэгдүүлж, хөгжүүлж, тэдний төлөвшилтийг сайжруулах чиглэлээр шат дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 1.5.3 Сумын хүүхдийн зөвлөл, хамтарсан багийн үйл ажиллагааг сайжруулж, гэр бүл, хүүхэд хамгааллын асуудлыг бодлогын төвд байлгана.
- 1.5.4 “Хүүхэд хөгжлийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.

#### 1.6 Залуучуудыг дэмжих чиглэлээр

- 1.6.1 Залуучуудын хөгжил төлөвшилтийг сайжруулж, нийгмийн оролцоог нэмэгдүүлж, идэвхтэй амьдралыг нь дэмжсэн бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.6.2 “Залуус бидний төлөө-бид залуусын төлөө” төсөл хэрэгжүүлж, залуусын оролцоотой төрийн бус байгууллагуудыг чадваржуулах бодлого хэрэгжүүлнэ.
- 1.6.3 Залуу гэр бүлийг дэмжсэн бодлого боловсруулан, гэр бүл төлөвлөлт, харилцаа хандлагыг дээшлүүлсэн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.6.4 Хүүхэд залуучуудын эрүүл мэндийг хамгаалах, тэдний бие бялдарт анхаарч, авьяасыг нээн илрүүлэх, хөгжүүлэх зорилгоор спортын төрлүүдээр жил бүр хавар, намрын спартикад явуулж хэвшинэ.

• 000000003

*(Handwritten signatures)*





### 1.7 Үндэсний бахархал, өв соёл, спорт

- 1.7.1 Соёлын салбарын хүний нөөцийг чадавхжуулж, дэмжлэг үзүүлнэ.
- 1.7.2 Тахилгат уул, ус, газар нутгийн мэдээллийн санг бүрдүүлж, тахин шүтэх ёсыг түгээн дэлгэрүүлэх журам боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 1.7.3 Иргэд идэвхтэй хөдөлгөөн хийх, уулын болон явган аялал, дугуйн спорт зэрэг нийтийн биеийн тамирын төрлийг дэмжиж, хамрах хүрээг өргөжүүлж, спорт талбайн тоног төхөөрөмжийг нэмэгдүүлнэ.
- 1.7.4 Түүх соёлын өвийг сүйтгэж байгаа хууль бус үйл ажиллагаатай хатуу тэмцэж, хариуцлагыг чангатгаж соёлын өвийг хадгалан хамгаалж, өвлүүлэн, баяжуулан хөгжүүлж буй соёлын биет бус өв тээгч нарыг урамшуулах тогтолцоог бүрдүүлнэ.
- 1.7.5 Хоёр жилд 1 удаа соёл урлагийн өдрүүдийг суманд зохион байгуулж ардын авьяастнуудыг нийтэд сурталчилж алдаршуулна.
- 1.7.6 Соёл урлагийн байгууллагын үйл ажиллагааг хөдөөд чиглүүлж соёлын төвийн хамт олныг авто машинтай болгоно.

### ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

- 2.1 Орон нутгийн төсвийг хэмнэлттэй, үр ашигтай төлөвлөн төсвийн орлогын бүрдүүлэлтийг сайжруулж, санхүүгийн алдаа зөрчлийг бууруулах, салбарын боловсон хүчний мэдлэг чадварыг дээшлүүлэх, төсвийн ил тод байдлыг хангах зорилгоор “Тунгалаг санхүү” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.2 Иргэн, айл өрх бүр хуримтлал үүсгэн эдийн засгийн хямралд өртөхөөс сэргийлэх, мөнгөн урсгалыг дотооддоо хадгалан, өрхийн төсөв болон аймаг орон нутгийн эдийн засагт эергээр нөлөөлөх “Хуримтлалтай хонгорчууд” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.3 Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжиж, блокны үйлдвэрлэлийг өргөтгөж, түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглан улаан тоосго үйлдвэрлэх ажлыг судална.
- 2.4 Сумын төвийн цахилгааны шугам сүлжээний хүчин чадлыг сайжруулж шаардлагатай газруудад өргөтгөл хийнэ.
- 2.5 Спорт зааланд их засвар хийж, соёлын төвийг сүүлийн үеийн техник, тоног төхөөрөмжөөр хангана.

#### 2.1 Төрөлжсөн аялал жуулчлал

- 2.1.1 Аялал жуулчлалын мастер төлөвлөгөөг хэрэгжүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжийг бүх талаар нь дэмжинэ.
- 2.1.2 “Нутгаараа бахархах” хөтөлбөр боловсруулж дотоодын аялал жуулчлалыг дэмжин, иргэдийг дотооддоо аялах ажлыг зохион байгуулж хэвшүүлнэ.
- 2.1.3 Аялал жуулчлалын бааз байгуулах бололцоотой газруудад хөрөнгө оруулалт хийх санал ирүүлсэн аж ахуйн нэгж, иргэнийг дэмжиж ажиллана.
- 2.1.4 Аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, иргэдэд хүү багатай, хөнгөлөлттэй зээлд хамруулж үйл ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр дэмжиж төсөл хөтөлбөрт хамруулна.

#### 2.2 Дэд бүтэц

000000004

*(Handwritten signatures and initials)*





- 2.2.1 Үүрэн телефоны хамрах хүрээг нэмэгдүүлэх, сумын хэмжээнд бүх газарт гар утсаар ярих боломжийг судалж Цэлгэрийн 4 дүгээр багт Жи-Мобайлын сүлжээний антен суурилуулна.
- 2.2.2 Гудамж талбайн гэрэлтүүлэг, тохижилтыг хийж гүйцэтгэнэ.
- 2.2.3 Сумын төвийн гудамж талбайг камержуулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлыг эрчимжүүлнэ.
- 2.2.4 Сумын төвийн нэгдсэн халаалтын хүчин чадлыг нэмэгдүүлж айл өрхүүдийг дулааны шугам сүлжээнд холбох ажлыг үргэлжлүүлнэ.
- 2.2.5 Богд сумын Түйн гол дээр баригдаж байгаа төмөр бетонон гүүрийг барьж дуусган ашиглалтад оруулна.
- 2.2.6 Сумын төвд 2 км хатуу хучилттай авто зам тавьж тоосжилтыг бууруулна.

### ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

- 3.1 Нутгийн удирдлагын ордныг шинээр барьж, ашиглалтад оруулах асуудлыг судалж шийдвэрлүүлнэ.
- 3.2 Төрийн албан хаагчийн “Нийгмийн баталгааг хангах” хөтөлбөр, төрийн албан хаагчийн “Сургалтын хөтөлбөр”-ийг батлуулан хэрэгжүүлнэ.
- 3.3 Төрийн албаны хүнд суртал, ашиг сонирхлын зөрчлийг бүрэн арилгаж, иргэн төвтэй засаглалыг бүрдүүлнэ.
- 3.4 Төрийн албаны шийдвэр гаргах үйл явцад иргэд саналаа өгөх, хяналт тавих боломж бүхий цахим системийг нэвтрүүлнэ.
- 3.5 Төрийн байгууллагуудын дотоод дэг журам, алба хаагчдын ажлын уялдаа холбоог сайжруулж, ажлын чанар, хариуцлагыг нэмэгдүүлнэ.
- 3.6 Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, малын хулгайтай тэмцэхэд иргэн, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг дэмжих замаар мал сүргийг гэмт халдлагаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 3.7 Төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах, нийтийн орон сууц барих асуудлыг судалж шийдвэрлэн ипотекийн зээлд хамруулна.
- 3.8 Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр ажил гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг иргэдийн болон ТББ-ын оролцоотойгоор нээлттэй ил тод явуулдаг зарчмыг бүрдүүлэхийн зэрэгцээ худалдан авах үйл ажиллагаанд хөндлөнгийн байгууллагын хяналт тавьж ажиллуулна.
- 3.9 Багийн төвүүдийг ээлж дараатай тохижуулж, 2,5 дугаар багийн төвийг барьж байнгын үйл ажиллагаатай болгоно.
- 3.10 Төрийн байгууллагуудын шийдвэрийг ард иргэдэд түргэн шуурхай хүргэж эргэх тогтолцоотой ажиллана.
- 3.11 Багийн хурал уулзалт, өдөрлөг, оторчдын баяр, шашин урлагийн цэнгүүн, үйлдвэрлэл эрхлэгчдийн өдөрлөг, малчдын зөвлөгөөн, төрийн албан хаагчдын зөвлөгөөнийг өргөн хүрээтэйгээр зохион байгуулна.

### ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

000000005





- 4.1 Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын менежментийг боловсронгуй болгож, төр хувийн хэвшил, иргэний нийгмийн түншлэлээр хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулна.
- 4.2 Түүх, соёлын дурсгалт газар, ус, ой, ховор амьтан, ургамлын тархац бүхий нутаг, өвөрмөц тогтоцтой эко системийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авч, тухайн бүс нутагт ажиллаж амьдарч буй иргэд, бүлэг нөхөрлөлтэй хамтран хамгаалалтын оновчтой бодлого хэрэгжүүлнэ.
- 4.3 Зэрлэг ан амьтдад хоол тэжээлийн био техникийн арга хэмжээг тогтмол авна.
- 4.4 Сумын төвийн тохижилтын хүрээнд айл өрх, албан байгууллага бүх нийтийн эзэмшил газруудыг тохижуулах, зүлэгжүүлэх, мод тарих ажлыг бүх нийтийн ажил болгон хэрэгжүүлнэ.
- 4.5 Сумын төвийн хог хаягдлыг дарж булшлан эзлэх талбайг багасгаж, хяналтын камертай болгож, хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлж зөрчил гаргасан иргэдэд хариуцлага хүлээлгэнэ.
- 4.6 Цөлжилтийг багасгах, элсний нүүдлийг саармагжуулах, хүн амын ая тухтай орчинд амьдрах, малын бэлчээр, усыг хамгаалах зорилгоор “Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөрийн хүрээнд аймаг орон нутгийн төсөв болон бусад их үүсвэрийг ашиглан “Ногоон Богд” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 4.7 Булаг шандны эхийг хүн, малаас хамгаалах, хаших ажлыг үргэлжлүүлнэ.
- 4.8 Айл өрх, албан байгууллагын эзэмшлийн хашаа, олон нийтийн зам талбайг ногоон байгууламжтай болгож тохижуулах ажлыг хэрэгжүүлнэ.
- 4.9 Байгаль орчны эсрэг аливаа гэмт хэргийг шуурхай илрүүлэх, таслан зогсоох, гэм буруутай этгээдээр байгальд учруулсан хохирлыг нөхөн төлүүлдэг тогтолцоог бий болгоно.
- 4.10 Бэлчээрийн хортон мэрэгч устгах ажлыг үе шаттай зохион байгуулна.

#### **ТАВ. ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ**

- 5.1 “Шинэ хөдөө” хөтөлбөр хэрэгжүүлж хөдөөгийн иргэдээ хөгжүүлнэ.
- 5.2 Алслагдсан болон отрын бүс нутгийг усжуулж бэлчээрийн даацыг нэмэгдүүлэх ажлыг шат дараатай хэрэгжүүлж “Бэлчээрийн загвар сум” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 5.3 “Шилмэл хээлтүүлэгчийн сан” хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.
- 5.4 Малчдын эм тамганы судалгааг гарган бүртгэлжүүлж малын хулгайтай тэмцэнэ.
- 5.5 Малчдын талаар төрөөс баримтлах бодлого “Монгол мал” хөтөлбөрийг үргэлжлүүлэн эрчимтэй хэрэгжүүлж иргэд, малчид хөдөлмөрөөрөө хорших, бүлэг, нөхөрлөл байгуулах ажлыг дэмжиж урамшуулдаг тогтолцоог бий болгоно.
- 5.6 Мал сүргийн тоонд бус чанартай, өндөр ашиг шимтэй, таваарлаг байдалд тулгуурлан бэлчээрийн даацад тохируулан өсгөх ажлыг бодлогоор дэмжин “Мал аж ахуйн тогтвортой хөгжлийн бодлого”-ыг хэрэгжүүлнэ.
- 5.7 Сумын хэмжээнд малын эрүүл мэндийг хамгаалах ажлыг нэн түрүүнд тавьж, мал эмнэлгийн үйлчилгээнд тавих хяналтыг сайжруулна.
- 5.8 Аж ахуйн нэгж, өрхөөс гахай, шувуу, зөгийний аж ахуй эрхлэхээр ирүүлсэн саналыг бүх талаар дэмжиж хамтран ажиллана.
- 5.9 Газар тариалангийн салбарт ажиллагсдыг хүлэмж, зоорь, хөнгөлөлттэй зээл, тоног төхөөрөмжөөр хангах арга хэмжээг авна.

000000006

*(Handwritten signature)*



- 5.10 Малын тэжээлийн ургамал тариалах ажлыг эрчимжүүлнэ.
- 5.11 Орон нутагт хадлан бэлтгэхийг хориглосонтой холбогдуулан хадлан бүхий бусад аймгуудтай гэрээ хэлэлцээр байгуулан өвс бэлтгэлийн ажлыг зохион байгуулж үнийн хөөрөгдлийг багасгах, тогтвортой байлгах барих бодлого барина.
- 5.12 Шаардлагатай газарт уст цэгийн хайгуул хийж бэлчээр усжуулна.
- 5.13 Хөдөө аж ахуйн салбарт малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх "Илгээлтийн эзэн-III" аяныг хэрэгжүүлж, малжуулах төслийн үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 5.14 "Монгол мал-2" хөтөлбөрийг хэрэгжүүлж, малыг эрүүлжүүлэх, чанар, ашиг шимийг сайжруулах ажлыг эрчимжүүлж, малын тоог чанарт шилжүүлж ашиг шим, хүртээмжийг сайжруулах, малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлнэ.
- 5.15 Малын халдварт өвчин тархах, давтамжийн судалгааг үндэслэн мал эмнэлгийн цогц арга хэмжээг эрчимжүүлж, эрүүл бүс нутаг гэсэн статусаа баталгаажуулна.
- 5.16 Сумын хэмжээний малчид, төлчдын зөвлөгөөнийг зохион байгуулж, нутгийн мал сүргийг сурталчлах ажлуудыг зохион байгуулна.


МЭДЭЭЛЛИЙГ БИЧСЭН

БОГД СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫГ ТӨЛӨӨЛЖ

ДАРГА



Д.ӨЛЗИЙБАЯР



000000007